**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Налайх тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: НТАГ-2024/53/НА-СТА-ОНА**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2023 он | Эвиденсе аудит ХХК-ийн захирал: С.Бадамгарав<br>Утас: 99057121 Цахим хаяг:info@evidenceaudit.mn<br>Аудитын менежер: Т.Болортуяа<br>Утас: 99017537 Цахим хаяг: Bolortuya@evidenceaudit.mn<br>Ахлах аудитор: Д.Мөнхжаргал<br>Утас: 70007121 Цахим хаяг: Munkhjargal.evidence@gmail.com<br>Аудиторын туслах: Э.Билгүүн<br>Утас: 95047121 Цахим хаяг: Bilguun@evidenceaudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт** /Баталгаажсан хувийг оруулах/


ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn


2024. 03.15 № 633

танай ______________-ны №______________-т

НАЛАЙХ ТОХИЖИЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Ц.ЭРБОЛ ТАНАА

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Налайх тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ -ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Налайх тохижилт үйлчилгээ ОНӨААТҮ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Нийслэлийн засаг даргын захирамжаар 800.7 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй, нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1.1.1 | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 26,387,119.43 | 10,433,507.12 |
| 1.1.2 | Дансны авлага | 0.00 | 76,591,870.00 |
| 1.1.6 | Бараа материал | 71,493,210.00 | 108,700,682.00 |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **97,880,329.43** | **195,726,059.12** |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 8,870,911,089.79 | 8,291,098,263.25 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 91,225,750.00 | 91,225,750.00 |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **8,962,136,839.79** | **8,382,324,013.25** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **9,060,017,169.22** | **8,578,050,072.37** |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 158,926,030.04 | 251,744,782.83 |
| 2.1.1.3 | Татварын өр | 644,471,400.88 | 382,733,402.20 |
| 2.1.1.4 | НДШ - ийн өглөг | 45,004,666.80 | 23,871,800.07 |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 848,402,097.72 | 658,349,985.10 |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | 7,531,890,812.62 | 0.00 |
| 2.1.2.6 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 7,531,890,812.62 | 0.00 |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **8,380,292,910.34** | **658,349,985.10** |
| 2.3.1 | Өмч: - төрийн | 1,031,531,894.26 | 9,147,562,366.44 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 1,353,362,538.43 | 1,353,362,538.43 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | (1,705,170,173.81) | (1,705,170,173.81) |
| 2.3.10 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | (876,054,643.79) |
| **2.3.11** | **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **679,724,258.88** | **7,919,700,087.27** |
| **2.4** | **Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн** | **9,060,017,169.22** | **8,578,050,072.37** |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 1,766,382,670.31 | 2,536,184,446.71 |
| 2 | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 982,492,755.50 | 1,934,998,748.65 |
| 3 | Нийт ашиг (алдагдал) | 783,889,914.81 | 601,185,698.06 |
| 4 | Түрээсийн орлого | 4,678,920.00 | 4,403,400.00 |
| 5 | Хүүний орлого | 0.00 | 188,124.97 |
| 6 | Бусад орлого | 1,299,108,512.92 | 0.00 |
| 7 | Ерөнхий ба удирдлагын зардал | 2,225,571,956.48 | 1,385,411,094.71 |
| 8 | Бусад зардал | 664,936,191.11 | 96,420,772.11 |
| 9 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | (802,830,799.87) | (876,054,643.79) |
| 10 | Татварын дараах ашиг (алдагдал) | (802,830,799.87) | (876,054,643.79) |
| 11 | Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал | (802,830,799.87) | (876,054,643.79) |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг | НИЙТ ДҮН |
|---|---|---|---|---|
| **2022 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл** | 1,031,531,894.26 | 1,353,362,538.43 | (1,705,170,173.81) | 679,724,258.88 |
| **2023 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл** | 1,031,531,894.26 | 1,353,362,538.43 | (1,705,170,173.81) | 679,724,258.88 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 8,116,030,472.18 | - | - | 8,116,030,472.18 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | (876,054,643.79) | (876,054,643.79) |
| **2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл** | 9,147,562,366.44 | 1,353,362,538.43 | (2,581,224,817.60) | 7,919,700,087.27 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **920,122,431.01** | **2,519,072,510.47** |
| | Татаас, санхүүжилтын орлого | 727,723,300.00 | 1,811,010,000.00 |
| | Бусад мөнгөн орлого | 182,899,131.01 | 708,062,510.47 |
| **1.2** | **Мөнгөн зарлага (-)** | **910,405,494.25** | **2,507,105,987.77** |
| | Ажиллагчдад төлсөн | 346,077,395.00 | 693,231,844.00 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө | 93,366,209.00 | 238,000,000.00 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 55,314,513.00 | 173,287,683.00 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 8,897,040.00 | 19,600,659.33 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 248,122,772.00 | 717,511,960.00 |
| | Татварын байгууллагад төлсөн | 270,529,345.25 | 292,883,804.69 |
| | Бусад мөнгөн зарлага | 131,568,220.00 | 372,590,036.75 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **9,716,936.76** | **11,966,522.70** |
| **2.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **726,154.69** | **150,764.99** |
| | Хүлээн авсан хүүний орлого | 726,154.69 | 150,764.99 |
| **2.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **6,750,000.00** | **28,070,900.00** |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 6,750,000.00 | 28,070,900.00 |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(6,023,845.31)** | **(27,920,135.01)** |
| **4** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **3,696,091.45** | **(15,953,612.31)** |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,421,648.00 | 26,387,119.43 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 5,114,739.45 | 10,433,507.12 |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн цалин, нэмэгдэл, | 965,457,557.73 | 864,414,002.05 | 101,043,555.68 | 89.53 |
| 2 | НДШ-ийн зардал | 128,451,789.84 | 122,568,581.56 | 5,883,208.28 | 95.42 |
| 3 | Сэлбэг, засварын зардал | 139,184,500.00 | 185,318,731.00 | (46,134,231.00) | 133.15 |
| 4 | Цэвэр бохир ус | 1,705,200.00 | 1,070,724.50 | 634,475.50 | 62.79 |
| 5 | Гэрэл цахилгааны зардал | 9,576,000.00 | 7,838,235.78 | 1,737,764.22 | 81.85 |
| 6 | Дулааны зардал | 9,733,760.00 | 6,844,968.55 | 2,888,791.45 | 70.32 |
| 7 | Тэтгэмж | 29,295,000.00 | 22,448,990.00 | 6,846,010.00 | 76.63 |
| 8 | Эд хогшил авах | 3,600,000.00 | | 3,600,000.00 | - |
| 9 | Хэвлэл захиалга, шуудан холбоо, гар утасны зардал | 1,560,000.00 | 1,104,400.00 | 455,600.00 | 70.79 |
| 10 | Дотоод томилолтын зардал | 625,000.00 | | 625,000.00 | - |
| 11 | Банкны шимтгэл, татвар, төлбөр хураамж | 9,329,200.00 | 15,450,517.20 | (6,121,317.20) | 165.61 |
| 12 | Гэрээний шимтгэл 23% | 173,880,000.00 | 66,736,640.69 | 107,143,359.31 | 38.38 |
| 13 | Шатахууны зардал | 508,044,300.00 | 576,541,284.60 | (68,496,984.60) | 113.48 |
| 14 | Бичиг хэргийн зардал | 5,886,000.00 | 6,325,316.00 | (439,316.00) | 107.46 |
| 15 | Хөдөлмөр хамгаалал | 31,084,000.00 | 22,372,340.00 | 8,711,660.00 | 71.97 |
| 16 | Бараа материал | 84,722,000.00 | 132,641,668.78 | (47,919,668.78) | 156.56 |
| 17 | Тохижилтын зардал | - | 49,779,300.00 | (49,779,300.00) | |
| 18 | Хог тээвэр. Бусад | 35,000,000.00 | 131,869,410.00 | (96,869,410.00) | 376.77 |
| 19 | Нохой устгал | | 11,385,000.00 | (11,385,000.00) | |
| 20 | Бусад зардал | 15,000,000.00 | 13,232,362.22 | 1,767,637.78 | 88.22 |
| 21 | Түрээсийн зардал | 14,400,000.00 | 27,200,000.00 | (12,800,000.00) | 188.89 |
| 23 | Даатгал | 0.00 | 1,454,220.00 | (1,454,220.00) | |
| 24 | Тээврийн зардал | 0.00 | 2,774,020.00 | (2,774,020.00) | |
| 25 | Аудит төлбөр | 0.00 | 1,500,000.00 | (1,500,000.00) | |
| 26 | Цэвэрлэгээ үйлчилгээ | 0.00 | 1,576,980.00 | (1,576,980.00) | |
| 27 | Элэгдлийн зардал | 1,085,503,403.00 | 1,144,382,922.54 | (58,879,519.54) | 105.42 |
| **Дүн** | | **3,252,037,710.57** | **3,416,830,615.47** | **(164,792,904.91)** | 105.07 |
| 1 | Санхүүжилт | 1,611,010,000.00 | 1,811,010,000.00 | 200,000,000.00 | 112.41 |
| 2 | НААХХУХ | 241,200,000.00 | 309,543,580.00 | 68,343,580.00 | 128.33 |
| 3 | Үйл ажиллагааны орлого | 134,500,000.00 | 396,958,883.71 | 262,458,883.71 | 295.14 |
| 4 | ЗДТГ-ийн нөөц сангаас | | 18,671,983.00 | 18,671,983.00 | |
| 5 | Түрээс | 4,426,500.00 | 4,403,400.00 | (23,100.00) | 99.48 |
| 6 | Хүүний орлого | | 188,124.97 | 188,124.97 | |
| | **Дүн** | **1,991,136,500.00** | **2,540,775,971.68** | **549,639,471.68** | **127.60** |
| | **Зөрүү** | **(1,260,901,210.57)** | **(876,054,643.79)** | | |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

*Илрүүлэлт-1:*

Тайлант хугацаанд бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудад шилжүүлсэн дүнг цахим и-баримтын худалдан авалтын дүнтэй тулган шалгахад 229,244.2 мянган төгрөгийн зөрүүтэй бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. *“Анхан шатны шатны бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”,* Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2. *“бараа, ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно*”; 17.6. *“Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй*” заалтыг зөрчсөн, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Худалдан авалтад төлсөн төлбөрийн баримтын шивэлтийг И-баримтын системтэй тулган хяналт тавих;

*Илрүүлэлт-2:*

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 100 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад тайлант онд 242,224.8 мянган төгрөгийн 17 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд:

Шилэн дансны цахим хуудаст цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 138,184.8 мянган төгрөгийн орлогын 6 гүйлгээ, 104,040.0 мянган төгрөгийн зарлагын 11 гүйлгээг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 *"Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх,* 6 дугаар зүйлийн “6.4 дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалттай нийцээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Албан шаардлага хүргүүлсэн.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Харилцагч байгууллагаас авсан | 1 | 229,244.2 | | | | | 1 | 229,244.2 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| бараа, үйлчилгээний төлбөрийг e-barimt-ийн цахим төлбөрийн баримтыг үндэслэн шилжүүлэг хийгээгүй. | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **229,244.2** | | | | | **1** | **229,244.2** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд 17 мэдээллийг байршуулаагүй. | 1 | 242,224.8 | | | 1 | 242,224.8 | | |
| **Дүн** | **1** | **242,224.8** | | | **1** | **242,224.8** | | |

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | | | | | | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | 1 | | | 1 | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | | **1** | | | **1** | | | |